



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БОЛОН
БАЯНГОЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ДАВГАМӨНХИЙН
БАТТӨМӨР ТАНАА

2020.09.03 № СХА-А020/06-НА-57
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн болон Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Давгамөнхийн Баттөмөрийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сэлэнгэ аймгийн болон Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Д.Баттөмөр нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020783

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Д.Баттөмөрийн Сэлэнгэ аймгийн болон Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Д.Баттөмөрийн мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сэлэнгэ аймгийн болон Баянгол сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМАГ БОЛОН БАЯНГОЛ СУМЫН 2020 ОНЫ ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ДАВГАМӨНХИЙН БАТТӨМӨРИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



УРИА: Нэг сэтгэлээр орон нутгаа хөгжүүлэе

Нэгдүгээр бүлэг: Хайр дүүрэн орчинд өсөж, хүмүүжих хүүхдүүд

- 1.1 Эх нялхас, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалж, өсвөр залуу үеийнхэндээ эх орноороо бахархах, үндэсний хэл соёл, уламжлалаа дээдэлдэг, бүтээлч сэтгэлгээтэй арга ухаанд суралцсан, өрсөлдөх чадвартай, хөдөлмөрч, хүмүүнлэг хүнийг төлөвшүүлэхэд анхаарч ажиллана.
- 1.2 Багш, сурагчдын хөгжлийг дэмжих цахим сургалтын орчныг ухаалаг технологид шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх, өндөр хурдны интернэтэд сургуулиудыг холбох зэрэг ажлуудыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч зохион байгуулна.
- 1.3 Сумдын сургууль, цэцэрлэгийн нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх саналыг холбогдох байгууллагад уламжилна.
- 1.4 Аймаг, сум, сургуулийн номын сангийн фондыг үндэсний болон дэлхийн сонгодог уран зохиолын номуудаар баяжуулж, сургууль, цэцэрлэгийг цахим номын сантай болох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 1.5 Хүүхэд хамгааллын асуудлыг чухалчлан үзэж, хүүхэд хөгжил, хамгааллын төвүүдийг дэмжинэ.
- 1.6 Сурагчдад авьяас чадвар, хүсэл сонирхлоо харгалзан мэргэжлээ зөв сонгох, ирээдүйн чиг баримжаа олоход тусалж энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудыг дэмжиж, хамтран ажиллана.
- 1.7 Шаардлагатай сургууль, цэцэрлэгт засвар ба өргөтгөл хийлгэх, нэн шаардлагатай байгаа багаж хэрэгсэл тоног төхөөрөмж байршуулах ажлыг холбогдох байгууллагуудад уламжлан, шийдвэрлүүлнэ.

**Хоёрдугаар бүлэг: Эрдэм мэдлэгтэй, өрсөлдөх чадвар
Бүхий залуу үе**

- 2.1 Хувийн хөрөнгөөр спортын талбай, цогцолбор барьсан аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, сумандаа спортын талбай, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.2 Урлаг соёл, спортын салбарт улсын болон олон улсын түвшинд амжилттай байгаа залуусыг дэмжиж ажиллана.
- 2.3 Зүүнхараа политехникийн коллеж болон Шаамар, Сүхбаатар сумдын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг түшиглэн насанд хүрэгчид, залуучуудад жижиг дунд, өрхийн үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр мэргэжил олгох гадаад, дотоодын холбогдох мэргэжлийн байгууллагуудад зуучлан дадлагажуулж, мэргэжилтэй ажилтан залуучуудыг бэлдэхэд анхаарч ажиллана.

- 2.4 Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн үйл ажиллагааг өргөтгөх, дадлагын бааз, тоног төхөөрөмжийг шинэчлэх, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, суралцагсдын суралцах сонирхлыг дэмжиж, холбогдох байгууллагуудад уламжлан, шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.
- 2.5 Залуучуудын хөгжих, тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн клуб холбоод ТББ-ыг дэмжиж, хамтран ажиллана.



Гуравдугаар бүлэг: Ахмад үе

- 3.1 Одоо байгаа ахмадын сувиллуудын орчин нөхцөлийг сайжруулах ажлыг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.
- 3.2 Ахмад настны халамжийн үйлчилгээг нэмэгдүүлэх бодлого баримтлан, хүнс тэжээлийн хөтөлбөрийг нэмэгдүүлэх, ахмадад хүнсний талон олгох асуудлыг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 3.3 Ахмад настны эдийн засгийн оролцоог нэмэгдүүлж, туршлага мэдлэгээ хуваалцах, сайн дурын ажил эрхлэх боломжоор хангах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран, дэмжиж ажиллана.
- 3.4 Ахмад настны нийгмийн оролцоог дэмжиж, ахмадуудад зориулсан олон нийтийн арга хэмжээ, нийгмийн үйлчилгээг хөгжүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 3.5 Ахмадын хороо зөвлөлийн ажлыг шинэ түвшинд гаргаж, төрөөс үзүүлэх санхүүжилт дэмжлэгийг нэмэгдүүлэх саналыг холбогдох байгууллагуудад уламжлан хамтран ажиллаж, ахмадуудынхаа чөлөөт цагаа өнгөрүүлэх, орчин нөхцөлийг сайжруулахад анхаарч ажиллана.

Дөрөвдүгээр бүлэг: Орон нутгийн ирээдүйг харсан хөгжил

4.1 Аялал жуулчлал, тээвэр

- 4.1.1 Ээж мод, Сайхны хөтөл, Алтанбулаг, Ноён-Уул, Хонин нуга, Ерөөгийн халуун рашаан, Амарбаясгалант хийд гэх мэт аялал жуулчлалын бүс нутгуудад жуулчдад иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ бий болгох ажлыг дэмжиж, холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 4.1.2 Усан замын аялал жуулчлалыг шинээр хөгжүүлэх, Орхон Сэлэнгийн бэлчир, Сэлэнгэ, Орхон, Ерөө, Хараа голын түүхэн болон үзэсгэлэнт газруудаар аяллын маршрутыг бий болгох санал санаачилга гаргаж, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 4.1.3 Гол төв замуудыг түшиглэсэн орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг борлуулах жижиг дунд худалдааны цэгүүдийг бий болгох ажлыг дэмжиж ажиллана.


4.2 Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн шинэ үеийн загвар боломж бий болгоно.

- 4.2.1 Зөгийн аж ахуйг бүхий л талаар дэмжин өргөжүүлэхэд анхаарч, хамтран ажиллана.
- 4.2.2 Мандал суманд нэвтрүүлсэн, өдөрт 10 тонн тэжээл боловсруулах чадамж бүхий малын хүчит тэжээлийн үйлдвэрийг аль болох олон газруудад байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжиж, хамтран ажиллана.
- 4.2.3 Малын хүчит тэжээлийн үйлдвэр нэвтрүүлсэн газруудад Евро стандартын "Бяслаг"-ны үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжинэ.
- 4.2.4 Малчин өрхийн хоршсон хөдөлмөр, хот айлын сүү цагаан идээгээр хийсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд нэвтрүүлэх асуудлыг бүх талаар дэмжинэ.
- 4.2.5 Байгалийн бордоо бэлтгэх, чийгийн улаан хорхой үржүүлэх, цехийг байгуулах, өрхийн болон жижиг ногооны аж ахуйн талбайг экологийн бордоогоор хангах ажлыг дэмжиж ажиллана.
- 4.2.6 Фермерийн аж ахуйг хөгжүүлж, малчдыг цэвэр цусны эцэг малаар хангаж малын үүлдэрлэг чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулна.
- 4.2.7 Малын тэжээлийн ургамлыг тариалж, малын тэжээлийн үйлдвэрүүдтэй холбож, ажлын уялдааг хангахад анхаарч ажиллана.
- 4.2.8 Эрчимжсэн мал аж ахуй, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 4.2.9 Мал нядлах, маханд анхан шатны боловсруулалт хийх, ангилж савлах, яс махны гурил хийх жижиг үйлдвэр, цех байгуулах санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 4.2.10 Төмс, хүнсний ногоо хадгалах, зоорины тоог нэмэгдүүлж, улмаар угааж савлах, боловсруулалт хийх үйлдвэрийг байгуулах санал санаачилгыг дэмжиж, хамтран ажиллана.
- 4.2.11 Жимс жимсгэнэ, зөгийн аж ахуй зэрэг мал ургамлын гаралтай түүхий эдийг түшиглэсэн анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.
- 4.2.12 Элэгдэл, эвдрэлд орсон хөрсийг олон наст, буурцагт ургамал тариалах замаар сэргээх, бордоо, ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээг нэвтрүүлж, хөрсний үржил шимийг хамгаалан сайжруулж, таримал ургамлын хэмжээ чанарыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
- 4.2.13 Тариалангийн үйлдвэрлэлд таримлын зохистой сэлгээ мөрдөж, сэлгээнд ашигт таримал тариалсан, шинээр усалгаатай тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийг бодлогоор дэмжинэ.

4.3 Иргэдийн оролцоотой байгаль орчныг хамгаална.

- 4.3.1 Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагыг өндөржүүлж, орон нутаг болон иргэдтэй хамтарч ажиллах нөхцөл, бололцоог судалж, хэрэгжүүлнэ.
- 4.3.2 Уул уурхайн компаниудын тайланг иргэдэд тавиулах ажлыг тогтмолжуулж, нөхөн сэргээлт, хөдөлмөр хамгаалал, нийгмийн хариуцлага, ажлын байрны талаар мэдээлэл өгч үнэлэлт дүгнэлтээ иргэдээс авч байх асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.

- 4.3.3 Бичил уурхай эрхлэгчдийг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулан, бичил уурхай эрхлэх газрыг хууль ёсны дагуу олгож, тэднийг эрүүл мэндийн үзлэгт болон нийгмийн даатгалд хамруулах зэрэг хууль ёсны эрх ашгийг хамгаалах санал, санаачилга гаргаж, холбогдох байгууллагуудад уламжлан, шийдвэрлүүлнэ.
- 4.3.4 Байгальд ээлтэй байдлаар газрын хэвлийн баялгийг ашиглах, бичил уурхайчид хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг хууль журмын дагуу үйл ажиллагаа явуулах асуудлыг дэмжиж ажиллана.



Бие даан нэр дэвшигч

A handwritten signature in black ink, appearing to read 'Д.Баттөмөр', is written over the printed name.

Д.Баттөмөр

2020.07.24